

АНУ бүрэлдэн тогтсон түүхээс

(үргэлжлэл)

*Дэд доктор С.Ишдорж,
Монголын АНУ судлалын Төвийн зөвлөх*

АНУ-ын Үндсэн хуулийг амьдралд хэрэгжүүлэх том зорилт анхны Ерөнхийлөгч Жорж Вашингтоноор толгойлуулсан Засгийн газарт ноогджээ. Жорж Вашингтон 1789 оны 4 дүгээр сарын 30-нд Ерөнхийлөгчийн албан тушаалд орох ёслол дээр “АНУ-ын Үндсэн хуулийг сахин сэргийлж хамгаалах болно” гэж мэдэгджээ. АНУ хэдийгээр Их хурал (Конгресс), Ерөнхийлөгчтэй болсон нь ч гэсэн дээд өндөрлөгт шүүх засаглалгүй байсан учир Их хурал Холбооны шүүх байгуулах тухай тогтоол гаргав. Уг тогтоолд Дээд шүүхийг Ерөнхий шүүгч болон бусад таван шүүгчээр бүрдүүлэхээр заасны дагуу Ерөнхий шүүгчээр нэрт хуульч Жон Жэй болон бусад шүүгчдийг Ерөнхийлөгч томилсныг Их хурлын дээд танхим-Сенат зөвшөөрч сайшаав.

Их хурал Ерөнхийлөгчийн албанд туслах зорилгоор гүйцэтгэх засаглалын гурван департаменттай байхыг зөвшөөрөв. Ерөнхийлөгч Төрийн нарийн бичгийн даргаар Томас Жефферсоныг, Цэргийн департаментын тэргүүнээр Александр Гамильтоныг томилуулав. Түүнчлэн Засгийн газрыг эрх зүйн асуудлаар Ерөнхийлөгчид зөвлөж байх Ерөнхий Прокуроор Эдмунд Рандольфыг томилуулав.

Жорж Вашингтон шинэ Засгийн газрыг хамгийн их сэтгэл зовоосон асуудал-мөнгөний асуудалд юуны өмнө анхаарлаа хандуулав. Хувьсгалт дайн үед АНУ нь хун амаасаа болон гадаадаас ихээхэн хэмжээний мөнгө зээлдэж өр тавсан

байлаа. Дотооддоо улс орны онц эрхийг барьж байсан Эх газрын II Их хурал болон муж-улсууд хувьсгалт дайн хийж байсантай холбогдуулан хүн ам, аж ахуйгаас бэлэн мөнгийг нь тодорхой хугацааны дараа хүүтэйгээр эргүүлэн төлөх баримт бичиг олгон зээлдэж авсан бөгөөд гадаадын Франц, Голланд, Испани зэрэг орноос олон сая доллар зээлдэж авчээ. Гэтэл хувьсгалт дайн дууссаны дараа Конфедерацийн зүйл ангиудын дагуу байгуулагдсан Их хурал нь улс орны мөнгөн санхүүг арвижуулах болон хүн амд албан татвар ноогдуулан авах эрх мэдэлгүй байсанд олон америкчууд Эх газрын II Их хурал болон муж-улсуудаас хүн амд өрөө хүүтэйгээр эргүүлэн төлөх бичиг баримтад итгэлгүй болж, тэдгээрийг туйлын бага бэлэн мөнгөөр зүүн хойд муж-улсуудын хотуудын дамын наймаачин панзчидад худалдаж байжээ. Эдгээр панзчид нь дээрх бичиг баримтуудаар Засгийн газраас ихээхэн мөнгө авч баяжих зорилготой байсан байна.

Ийм нөхцөл байдалд Ерөнхийлөгч Жорж Вашингтон, Сангийн департаментын тэргүүн Александр Гамильтон нар дээрх өрийг төлөх зохистой арга замыг эрж хайв. Ийм арга замыг Гамильтон сэдэж, улс орны дотоод, гадаад өрийг төлж барагдуулах санхүүгийн төлөвлөгөөг Конгресст оруулав. Энэ төлөвлөгчид:

Нэгдүгээрт, Нэгдсэн улсыг болон муж-улсуудын өрийг нэгтгэн, нэг том өрийн тооцоо гаргах;

Хоёрдугаарт, Банкны системийг бий болгохдоо Филадельфи хотноо нэг төв банк байгуулж, бусад хотуудад түүний салбарыг ажиллуулах;

Гуравдугаарт, гадаадаас оруулж ирж байгаа бараа таваар, бүтээгдэхүүнээс гаалийн хураамж авахын зэрэгцээ дотоодын зарим нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнээс гаалийн татвар авч байх зэрэг зүйлүүдийг тусгажээ. Их хурлаар Гамильтоны энэхүү төлөвлөгөөнд тусгасан зүйлүүдийг хэлэлцэхэд үндэсний /нийт улс орны / ба муж-улсуудын өрийг нэгтгэн нэг том өрийн тооцоо болгож, Төв Засгийн газар хүн амд дахин баримт бичиг тараан мөнгө зээлдэж тодорхой хугацааны дараа хүүтэйгээр эгүүлэн төлөх, энүүгээр хуримтлагдсан мөнгийг хүн амаас авах албан татвар болон

гаалийн хураамж, мөн бас бусын бусад орлоготой нийлүүлээд улс орны дотоод, гадаад өрийг төлж барагдуулах саналыг өмнөдийн муж улсуудын нэлээд төлөөлөгчид эсэргүүцэв. Тэдний зарим нь тайлбарлахдаа дайны үед муж улсуудын зээлдсэн мөнгийг Төв засгийн газар төлөх хэрэггүй, муж улсууд өөрсдөө төлөх ёстой харин умард муж улсуудын хотын дамын панзчид бидний баримт бичгүүдийг маш бага үнээр худалдаж авсан учир тэдэнд баримт бичгийн үнийг бүрнээр төлж хэрхэвч болохгүй гэж ярин Гамильтоны төлөвлөгөөний энэ зүйлийг эрс эсэргүүцлээ. Түүний төлөвлөгөөг өмнөдийнхөн бүрмөсөн нурааж унагаалгахгүйн тулд Гамильтон өмнөдийн төлөөлөгчидтэй зохицох арга сэдэв. Тэр Жеймс Мэдисон болон өмнөдийн бусад удирдах хүмүүстэй ярилцаж тохирсоны үндсэн дээр АНУ-ын нийслэл хот умардад, өөрөөр хэлбэл Нью-Йорк, Филадельфид сэлгэн байрлаж байдаг өмнөдийнхөн дургүй байдгийг харгалзан, хэрвээ өмнөдийн муж улсуудын төлөөлөгчид Их хуралд үндэсний ба муж улсуудын өрийг нэгтгэн төлөх ба түүний төлөвлөгөөг дэмжвэл, түүнчдэн улс орны нийслэлийг байнга байрлуулах газрыг Мэрилэнд, Виржиниа муж улсуудын хооронд (заагт) байдаг Потомак голын эргийн дагуу газар өгвөл Их хурлаар үүнийг батлуулж чадахаа амлав. Өмнөдийн төлөөлөгчид Гамильтоны энэ амлалтыг зөвшөөрч, Их хуралд түүний төлөвлөгөөг дэмжихээр болов. Ийнхүү Холбооны Засгийн газрын байнга оршитх байрыг Потомак голын дагуух газарт байрлуулан, Америк тивийг нээсэн Колумбын нэрээр Колумба тойрог гэж нэрлэн, нийслэл хотыг Вашингтон гэж нэрлэх болжээ.

Гамильтоны төлөвлөгөөний хоёр дахь зүйлийг хэлэлцэхэд бас л эсэргүүцэл гарав. Томас Жефферсон болон бусад зарим хүмүүс эсэргүүцэж хэлэхдээ Үндсэн хуулиар Их Хурал (Конгресс)-д банк байгуулах эрх олгосон заалт байхгүй гэсэн нотолгоо ярьж байлаа. Үүний хариуд Гамильтон тайлбарлаж ярихдаа Үндсэн хуулинд яг банк байгуулах үг байхгүй ч гэсэн Их хурал (Конгресс) нь мөнгө зээлдэж, мөнгөний системийг зохицуулж болно гэсэн заалт байдаг учир энэ банк байгуулах гэж байгаа нь дээрх заалтыг

хэрэгжүүлэхийн нэг практик арга хэмжээ л дээ гэжээ. Ингээд Их хурал АНУ-ын анхны банк бий болгохыг зөвшөөрчээ.

Гамильтоны төлөвлөгөөний гурав дахь зүйлийг нэг их хурц эсэргүүцэлгүйгээр Их хурлын гишүүд зөвшөөрөн баталжээ. Гэтэл америкийн дотоодын зарим бараа таваар, бүтээгдэхүүнээс, тухайлбал виски архи худалдаалахаас хураамж авах болсон явдал ялангуяа Аппалачийн нуруунаас баруун тийшээх зах хязгаар нутгийн тариачдын эсэргүүцэлтэй тулгарлаа. Зах хязгаар нутгийн тэдгээр тариачид өөрсдийнхөө хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, тухайлбал ургац тариаг Аппалачийн нуруунаас зүүнтээх муж улсууд руу тээвэрлэн аваачиж худалдах унаа хөсөг дутмаг, зам муу зэргээс шалтгаалан үр тариагаа виски архи болгон нэрж түүнийгээ зүүн муж улсууд руу тээвэрлэн өндөр үнээр зарж их ашиг орлого олж байжээ. Тэгээд ч тэд орлого ашгаас нь хураамж авахаар очсон албаны хүмүүст мөнгө өгөхөөс эрс татгалзаж байлаа. Тэр ч байтугай 1794 онд Пенсильвани муж улсын баруун хэсэгт тариачид зэвсэг барин татварын албаны хүмүүсийг хүчлэн зайлуулахад нь Ерөнхийлөгч Жорж Вашингтон 13000 шахам цэрэг илгээж хүч үзүүлэхэд тэдгээр үймээн гаргасан тариачид арга буюу татвар хураамжаа төлсөн байна. Энэ бол Засгийн газар ямар ч цус урсгалгүйгээр засгийн хүчийг илтгэн харуулж асуудлыг хуулийн дагуу зөв зохистой шийдсэнийг гэрчилж байна. Ингэж засгийн газрын шийдвэрийг хүн амаар албадан хэрэгжүүлэх арга хэрэглэснээр улс орны дотоод, гадаад өрийг төлөх мөнгө хуримтлуулахад чухал үүрэг гүйцэтгэжээ.

Жорж Вашингтон тэргүүтэй гүйцэтгэх засаглалын нэр хүнд дотоодод өсч эхлэв. Ерөнхийлөгч Вашингтоны Засгийн газар бодлогын чиг шугамаа янз бүрийн үзэл бодлыг уралдуулах замаар тодорхойлж байлаа. Түүний командад ажиллаж байсан хүмүүс бодлогын чиглэлийг тодорхойлох талаар хоёр чиглэлд хуваагдаж байхад Ерөнхийлөгч өөрөө аль нэг талыг дагнан баримталдаггүй, харин нийт улс орон нэг л эрх ашигтай гэдэг байв. Гүйцэтгэх засаглалын зарим дээд зиндааны хүмүүс хоёр жигүүрт хуваагдсан нь Засгийн газрын бодлогын чиглэлийг тодорхойлох талаар хоёр нам үүсч бий

болгоход хүргэлээ. Үүнд: Төрийн нарийн бичгийн дарга Томас Жефферсон Жеймс Мэдисоны тусламжтайгаар Ардчилсан Бүгд Найрамдах намыг, сангийн департаментын тэргүүн Александр Гамильтон, Дэд ерөнхийлөгч Жеймс Адамс нар Холбооны (Федералист) намыг байгуулав. Ардчилсан Бүгд Найрамдах нам гэж нэрлэсэн учир бол улс орон Холбооны хүчтэй Засгийн газартай ямагт байхыг илэрхийлсэн хэрэг ажээ. Ардчилсан Бүгд Найрамдах Намыг дагалдан талархагчид нь голдуу фермерүүд, гар урчууд байлаа. Харин Холбооны (Федералист) Намын үзэл бодлыг гол төлөв зүүн хойд муж улсуудын худалдаа үйлдвэр эрхлэгчид, мануфактурын хүмүүс талархан дэмжиж байлаа. Тус хоёр намынхны аль аль нь Жорж Вашингтоныг гүнээ хүндэтгэдэг байв.

1792 оны сонгуулиар Жорж Вашингтон Ерөнхийлөгчөөр, Жон Адамс Дэд ерөнхийлөгчөөр дахин сонгогдлоо. Ингэж улиран сонгогдсоныхоо дараа Жорж Вашингтон гадаадад АНУ-ын нэр хүндийг дээшлүүлэх, гадаад орнуудын хүндэтгэлийг олох талаар хамтран зүтгэгчдийнхээ хамт анхаарлаа төвлөрүүлэв. Энэ үе нь 1789 онд Францад дээд ангийнхнй эсрэг тариачид, дунд ангийнхны бослого улам ширүүсч, 1793 онд хаан, хатныгаа босогчид цаазалсан байна. Үүнийг Их Британи, Австри, Пруссийн эрх баригчид маш эмзэглэн ажиглаж, Францын хувьсгалчид босогчдын жишээгээр эдгээр орны ард иргэд бас тэднийг ингэж магадгүй гэж айсандаа дээрх гурван орон Францад дайн зарлажээ.

АНУ-ын хувьд олон америкчууд анхандаа Францын хувьсгалыг америкийн хувьсгалтай адил мэт төсөөлөн талархаж байсан боловч сүүлдээ дээрх адал балмад зэрлэг явдал гарсанд гутран, хүмүүсийн санаа бодол хуваагдмал болжээ. Уул нь АНУ, Франц хоёр улс 1778 оны Холбоотны гэрээгээр бол бие биедээ туслах үүрэгтэй л дээ. Тэр гэрээ ёсоор хэrvээ Франц улс дайтаж байгаа бол АНУ бас дайтаж түүнд туслах байлаа. Энэ асуудлын талаар Ерөнхийлөгч Вашингтон, түүний зөвлөхүүд шийдвэр гаргах ёстой байв. Гүйцэтгэх засаглалын дээд удирдлагын дотор энэ асуудлаар санал хуваагдлаа. Томас Жефферсон болон бусад зарим хүмүүс, өөрөөр хэлбэл Ардчилсан Бүгд Найрамдах Намын

талынхан Холбооны гэрээний үүргийн дагуу Францад туслах нь зүйтэй гэж үзэж байхад Федералист намынхан Францад ардчилсан биш, өөдгүй муу дэглэм байгаа, мөн Британи нь АНУ-ын худалдааны чухал түнш учир Францад тусламж үзүүлэхийг эсэргүүцэж байлаа. Жорж Вашингтон Засгийн газрынхаа хуралдааныг хийж, федералистуудын саналыг авахаар шийдэв. Ингээд 1793 оны эхээр Европ дахь дайны асуудлаар АНУ төвийг сахих тухай мэдэгдэл хийв. Тэгэхдээ АНУ нь дайтаж буй улсуудын аль нэг талд орохгүй, харин тэдний аль алинтай нь худалдаа наймааны харилцаатай байна гэж дурджээ. Ерөнхийлөгчийн энэ шийдвэрийг Томас Жефферсон, Александр Гамильтон нар зөвшөөрч санал нэгдэв.

Гэтэл Их Британи нь өөр рүүгээ очсон АНУ-ын худалдааны хөлөг онгоцуудаас гадна Франц руу зорчиж байсан америкийн худалдааны хөлөг онгоцуудыг замаас нь булаан авч өөртөө аваачин хүмүүсийг нь баривчилж шорон гянданд хорьж байлаа. Их Британи тэр үед тэнгисийн хамгийн хүчирхэг гүрэн байсан тул түүний ийм явуулгыг бусад ямар ч улс орон зогсоож чаддаггүй байжээ. Түүгээр үл барам Их Британи тэнгисийн хүчирхэг байдлаараа түрий барин, 1783 оны Парисын гэрээгээр авсан үүргээ биелүүлэхээс татгалзаж АНУ-ын зүүн хойд хилд тэнгисийн цэргийн боомтоо хэвээр байлгаж байв. Түүнчлэн Британичууд америкийн индианчуудыг дэмжих зорилгоор тэдний ойролцоох газарт цайз боомтуудаа байлгаж, тэдэнд зэвсэг нийлүүлэн нууцаар тэднийг АНУ-ын Засгийн газрын эсрэг турхирч байлаа.

Британичууд нэг л өдөр АНУ-ын баруун умард газар нутаг дахин Английнх болно гэж найдаж байжээ. Нөгөөтэйгүүр индианчууд ч гэсэн цагаан арьстан суурьшигчдад элдэв аргаар газар нутгаа алдаж байгаагийн эсрэг тэмцэлдээ Британийн тусламж авна гэж тооцоолж байв.

Жорж Вашингтоныг хоёр дахь удаагаа сонгогдож байх үед АНУ-ын баруун умард нутагт индианчууд, цагаан арьстан суурьшигчдын хооронд зэвсэгт тэмцэл аль хэдийн эхэлсэн байлаа. Ерөнхийлөгч индианчуудын эсрэг хоёр удаа цэрэг илгээсэн боловч хоёулаа амжилт олоогүй байна. Гурав дахь

удаагаа Ерөнхийлөгч хувьсгалт дайны баатар генерал Антони Вейнигээр командлуулсан цэрэг илгээв. Генерал Вейни сайн сургуулилсан цэрэг командлан индиан замчид дагуулж баруун умард нутаг Огайо руу хөдөлжээ. 1794 оны 8 дугаар сарын 20-нд Вейни ялалт байгуулав. Түүний цэргүүд гуалин дүнд модоор бүрхэгдсэн талд шауни, оттава, чиппева индиан омгийнхны 2000 орчим хүнтэй бөөн хүчийг бут цохижээ. Ийнхүү унагасан ойн тулалдаан нь индианчуудыг өөрсдийн газар нутгаа хадгалж үлдэх гэсэн найдлагагүй болгожээ. Индианчууд өөрсдийнхөө төрөлх нутгаа орхиж, баруун тийш нүүжээ зөвшөөрсөн Гринвиллийн гэрээнд гарын үсэг зурсан байна.

Индианчуудын ялагдал нь индианчуудын туслалцаатайгаар АНУ-ын баруун умардын нутгийг эгүүлэн авах гэсэн британичуудын найдлагыг бас замхруулжээ. Тэгээд ч британичууд гэрээ байгуулах хэлэлцээ хийхээр АНУ-ыг урьжээ. АНУ хэлэлцээ хийхийг түргэн зөвшөөрч, Ерөнхий шүүгч Жон Жэйг Их Британи руу явуулав. Ингэснээр Ерөнхийлөгч Вашингтон шинэ тулгар орныг дайнд нэрвэгдүүлэхгүйг хичээсэн байна. Жон Жэй Британитай Жон Жэйгийн 2 гэрээг байгуулж, түүгээр Британи нь АНУ-ын баруун умард нутгийн хилийн дагуу цайз боомттой байх явдлаас татгалзжээ.

Жон Жэйгийн гэрээг америкийн олон нийт сайшаан хүлээж авсангүй. Ялангуяа Британи 1783 оны Парисын гэрээгээр авсан үүргээ тэр болгон биелүүлэхгүй, АНУ-ын зарим хил хязгаарт тэнгисийн цэргийн хөлөн онгоцос байлгасан хэвээр байсан, түүнчлэн америкийн тэнгисийн хөлөг онгоцуудыг булаан авч, тэдгээрийн хүмүүсийг шорон гянданд хорьж байгаа зэргийг болиулж чадаагүйг эрс шүүмжлэн дургүйцэж Жон Жэйгийн тухай шог зураг хүртэл хэвлэн нийтэлсэн байлаа. Гэвч Ерөнхийлөгч Жорж Вашингтон үзэхдээ Жон Жэй нь тийм үүрэг даалгавар аваагүй, харин Британитай дайтах аюулыг зайлуулах гол үүрэгтэй явсан, түүнийгээ биелүүлж ирсэн юм гэж Сенатад тайлбарласан учир Сенат уг гэрээг 1795 онд баталсан байна.

АНУ-ыг Британитай Жон Жэйгийн гэрээ байгуулсан явдалд Испани улс сандарч, АНУ, Британи хоёр хамтран хуйвалдаж Америк дахь Испанийн колонийг булаан авч болзошгүй гэж болгоомжлон айж, АНУ-тай түргэн хэлэлцээ хийж гэрээ байгуулан тохиролцохыг хичээв. Ерөнхийлөгч Жорж Вашингтон Томас Пинкнейг Испанитай гэрээ байгуулахаар явуулав. Уг гэрээ ёсоор америкчуудад Миссиссипи мөрнөөр зорчих, Нью-Орлеанд бараа таваар нийлүүлэх эрх олгож, түүнчлэн АНУ-ын Жоржиа муж улс, Испанийн Флоридын хоорондох хилийн шугамыг зохицуулжээ. Пинкнейгийн гэрээ нь асуудлыг АНУ-д тааламжтай шийджээ.

Жорж Вашингтон хоёр дахь удаагаа Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан хугацаа дуусах шатандаа орж байсан учир тэр өөрөө мэдэгдэл хийж түүндээ гурав дахь удаагаа сонгогдох дургүй байгаагаа зарлав. Өөрөөр хэлбэл тэр 1796 оны сонгуульд түүний нэрийг Ерөнхийлөгчөд дэвшүүлэхгүй байхыг хүсчээ. Жорж Вашингтон АНУ-ын анхны Ерөнхийлөгчөөр ажилласан хугацаандаа улс орныг эмх замбараатай болгож, амжилтанд хүрэх найдвартай чиг шугамд оруулж чадсан байна. Ингээд тэр Виржиниа дахь өөрийн дуртай эдлэндээ очиж ажиллаж байгаад 1799 онд 67 насандаа таалал төгсчээ.

Жорж Вашингтоныг Ерөнхийлөгчийн албан тушаалаа орхих тухай мэдэгдсэний дараа 1796 онд Ерөнхийлөгчийн сонгууль болохтой холбогдон Ерөнхийлөгчийн албан тушаалын төлөө Бүгд Найрамдах Намын (Ардчилсан Бүгд Найрамдах Нам өөрийгөө ингэж нэрлэх болсон), Холбооны Нам тэмцэлдэж, ерөнхийлөгчид өөр өөрийнхөө хүний нэрийг дэвшүүлэв. Бүгд Найрамдах Нам Томас Жефферсоны нэрийг, Холбооны Нам Жон Адамсын нэрийг дэвшүүлэв. Хоёр нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөртөө Францтай зарлаагүй дайн эхэлсэнтэй холбогдуулан хоёулаа Жорж Вашингтоны явуулж байсан бодлогыг үргэлжлүүлэхээ амласан боловч Засгийн газрын дотоод бодлогын чиг шугамын талаар аль аль нь юу ч амлаагүй байна. 1796 оны сонгуулийн дүн гарахад Жон Адамс сонгогчдынхоо 71 хувийг, Томас Жефферсон 68

хувийг авсан байлаа. Ингээд Жон Адамс ерөнхийлөгч, Томас Жефферсон дэд ерөнхийлөгч болж, хоёр өрсөлдөгч хамтран ажиллах болжээ.

Шинэ ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч ажлаа авах үед АНУ-тай Франц үнэн хэрэгтээ зарлаагүй дайны байдалтай байлаа. Их Британитай АНУ Жон Жэйгийн гэрээ байгуулсан явдалд Франц улс туйлын их дургүйцэж, АНУ-ыг түүнтэй 1778 онд гарын үсэг зурсан холбоотны гэрээний үүргээ зөрчиж, Францын дайсанд ая тал засан, Францад нөхөрсөг бус хандаж байна гэж үзэн, АНУ-ыг дайсагнасан ажил явуулгад шилжин орсон байв. Юуны өмнө АНУ-ын тэнгисийн худалдааны хөлөг онгоцуудыг Францын тэнгисийн цэргийн хүчин булаан авч байлаа. Тухайлбал богино хугацаанд францчууд америкийн худалдааны 300 гаруй вессель хөлөг онгоцыг булаан авсан байлаа. Ерөнхийлөгч Жон Адамс Францтай дайтах явдлыг зайлуулах үүднээс хэлэлцээ хийж гэрээ байгуулахаар өөрийн гурван дипломатыг Парис руу явуулжээ. Хэлэлцээ эхэлмэгц Францын тал АНУ-ын Засгийн газар Холбоотны гэрээний үүргийг зөрчиж ноцтой хохирол учруулсны төлөө ихээхэн хэмжээний төлбөр зээл олгож, Францын албаны хүмүүст 250.000 ам. долларын барьц барихыг шаардсан байна. Америкийн гурван дипломат иймэрхүү явдлыг хээл хахуул гэж үздэг учир тийм зүйлийг хийхээс эрс татгалзжээ. Тэгээд тэр гурван дипломат энэ тухайгаа ерөнхийлөгч Адамст годорхой илтгэл бичиж илгээсэн байна. Ерөнхийлөгч Адамс Францын талаас хэлэлцээ хийсэн гурван дипломатын нэрийг заалгүйгээр "XYZ (экс-уай-зет)" гэж нэрлэсэн нь уг хэрэг явдлыг "XYZ-ийн хэрэг явдал" гэж нэрлэжээ.

Америкийн олон нийт "XYZ-ийн хэрэг явдал"-ыг мэдмэгцээ Францад ихээхэн дургүйцэж "Батлан хамгаалах үйлсэд сая саяар нэмэрлэе, харин хээл хахуульд нэг ч цент нэмэрлэхгүй байя" гэсэн лоозон барьж эсэргүүцэж байжээ. Өөрөөр хэлбэл тэд Францад хээл хахууль төлсөнөөс түүнтэй дайтах нь хавьгүй дээр гэж хэлж байжээ. Ингээд ч 1798 онд АНУ-ын Конгресс Францтай 20 жилийн өмнө 20 жилийн хугацаатай байгуулсан Холбоотны гэрээг цуцалсан байна. Хоёр орны хоорондын худалдааны байдал улам муудаж далайд

тэмцэл эхэлсэн байлаа. АНУ хэдийгээр тэнгисийн цэргийн хүчээр Францаас хавьгүй сул байсан ч гэсэн гурван жил хүрэхгүй хугацаанд Францын 84 хөлөг онгоцыг сөнөөж чаджээ. Гэвч Францын Их хурал, Засгийн газар нь АНУ-д дайныг албан ёсоор зарлаж чадахгүй байлаа.

1800 онд Ерөнхийлөгч Адамс Энх тайвны хэлэлцээ хийхээр Франц руу дахин төлөөлөгчид явуулав. Энэ үед Францын засгийн эрхэнд Луи Бонапарт Наполеон орсон байлаа. Наполеон АНУ-тай тэмцлээ үргэлжлүүлэх дургүй байжээ. Ингээд хоёр орон тэнгис далайд аливаа тэмцлээ зогсоох тухай хэлэлцээр байгуулж гарын үсэг зурсан байна. Харин Францтай ийнхүү энх тайван байдал бий болгосныг ерөнхийлөгчийн харьяалагддаг Холбооны Намын олон гишүүд таашаахгүй, түүнийг “сул” ерөнхийлөгч хэмээн зэмлэн буруушааж байжээ.

Ерөнхийлөгч Адамсын гадаад бодлогод ийм нааштай алхам хийгдэж байсан ч гэсэн түүний дотоод бодлого, улс орны доторхи байдал сэтгэл түгшээсэн зарим үйл явдлаар тодорхойлогдож байлаа.

1798 онд Их хурал (Конгресс) Засгийн газрын эсрэг чиглэсэн ухуулгыг хязгаарлах тухай хууль гаргав. Их хуралд Холбооны намынхныг дэмжигч төлөөлөгчид давамгайлж байсныг ашиглаж Холбооны намынхан ийм хууль батлуулжээ. Түүнчлэн энэ хуулиар сонин хэвлэлийн ажилтнуудыг АНУ-ын иргэн болгох хугацааг сунгах (уул нь АНУ-д цагаачилж ирээд 5 жил байнга оршин сууж байгаа бол америкийн иргэн аяндаа болдог байсан бол энэ хуулиар байнга оршин суух хугацааг 14 жил болгож, түүний дараа америкийн иргэн болгох) тухай заасан нь ихээхэн учир шалтгаантай байжээ. Энэ хуулийг гаргаснаар Холбооны намынхан сөрөг нам Бүгд Найрамдах намынхныг Засгийн газрын эсрэг үг дуугаруулахгүй байх, ингэснээр өөрсдийн засаглалыг ирэх сонгуулиар хадгалж үлдэх, олонхи хэвлэлийн ажилтан, ялангуяа сонин хэвлэлийн сэтгүүлчид, мөн олон хүн АНУ-д цагаачилж ирээд удаагүй учир АНУ-ын иргэн болж чадахгүй, тэгээд сонгуульд оролцох эрх эдлэхгүй зэргийг тун нарийн бодолцож үзсэн хэрэг байжээ. Энэ хууль гарсаныг ашиглан, Холбооны намынхан

давамгайлсан Засгийн газрыг шүүмжилсэн Бүгд Найрамдах Намын талын 25 сонин сурвалжлагчийг баривчилж шорон гянданд хорьсон байна. Ингэж уг хууль нь хүмүүсийн үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хязгаарласнаар АНУ-ын Үндсэн хуулийг зөрчсөн хууль болжээ. Энэ хуулийг Томас Жефферсон болон Бүгд Найрамдах Намын бусад удирдах хүмүүс Конгресст үг хэлж эсэргүүцэж байсан нь тэдний нэр хүндийг олон түмний дунд улам нэмэгдүүлж, шинэ шинэ дэмжигчидтэй болж байв. Үүний үр дүнд Бүгд Найрамдах Намынхан 1800 оны сонгуульд олон санал авч, Томас Жефферсон Ерөнхийлөгчийн сонгуульд ялах боломжтой болжээ.

Шинэ XIX зууны эхний он- 1800 онд АНУ-д Ерөнхийлөгчийн сонгууль явагдсан нь чухал үйл явдал болов. Энэ сонгуульд Холбооны намынхан Жон Адамсыг, Бүгд Найрамдах Намынхан Томас Жефферсоныг Ерөнхийлөгчийн нэрд дэвшүүлэв. Сонгуулийн өмнөх компани ажил нэлээд хурц өрсөлдөөнтэй явагдаж, Бүгд Найрамдах Намынхан Нью-Йоркийн иргэн, хувьсгалт дайны баатар Аарон Бүррийг дэд ерөнхийлөгчийн нэрд дэвшүүлсэн байна. Сонгуулийн дүнд Бүгд Найрамдах Намын дэвшүүлсэн хоёр хүн ялж, энэ нам Их Хурлын хоёр танхимд хоёуланд нь олон суудал авснаар хууль тогтоох болон гүйцэтгэх засаглал Холбооны намынхнаас Бүгд Найрамдах Намынханд шилжжээ. Өөрөөр хэлбэл шинэ зуун АНУ-д улам өргөң ардчилал авчрах, тус орон улам өргөжин хүчирхэгжихийг зөгнөсөн зуун байлаа.

Томас Жефферсон бол АНУ-ын тусгаар тогтнолын Тунхаглалыг зохиож бичсэн, Виржиниа муж улсын парламентын болон эх газрын II их хурлын гишүүнээр сонгогдож байсан бөгөөд Виржиниа муж улсын захирагч, Францад АНУ-ын Элчин сайд, Ерөнхийлөгч Жорж Вашингтоны Засгийн газарт Төрийн нарийн бичгийн даргаар томилогдон ажиллаж, Ерөнхийлөгч Жон Адамсын үед дэд ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байв. Томас Жефферсон олон төрлийн мэдлэгтэй, Засгийн газрын ажлын их дадлага туршлагатай хүн байлаа.

Ерөнхийлөгчийн албан тушаалыг хүлээж авсаныхаа дараа Томас Жефферсон хэд хэдэн чухал арга хэмжээ авав. Үүнд:

-Цөөн орон тоотой чадварлаг Засгийн газар байх хэрэгтэй гэсэн зарчмыг баримтлан Төв Засгийн газрын аппаратын орон тоог цөөлж, Холбооны намынхны нэлээд олон ажилтныг ажлаас гаргажээ. Түүнчлэн Засгийн газар хүмүүсийн хувийн амьдралд хэт хутгалдан оролцохыг хязгаарлаж, үүний түрүүнд Их хурлын батласан Засгийн газрын эсрэг чиглэсэн суртал ухуулгын тухай хуулийг хүчингүй болгож, мөн виски архи болон америкийн бусад бараа таваар, бүтээгдэхүүнээс хураамж авдагийг болиулжээ. Хөдөө аж ахуйнхныг дэмжиж урамшуулахыг бас хичээсэн байна.

-Жорж Вашингтон, Жон Адамс нарын засаглалын үед Засгийн газрын зардал байнга өсч байсныг болиулж, түүнийг багасгах алхам хийжээ. Тухайлбал Их хурлын зөвшөөрч сайшааснаар тэнгисийн цэргийн тоог хорогдуулж, шинэ хөлөг онгоцууд бүтээхийг зогсоон, армид алба хашиж байсан 4000 цэргийг 2500 болгон цөөрүүлжээ. Ингэснээр тус орны төлөх ёстой өр 83 сая доллар байсныг 57 сая болгож багасгасан байна.

Томас Жефферсон тэнгис далайд хөвдөг америкийн худалдааны хөлөг онгоцуудыг булаан дээрэмддэг үйлдлийн эсрэг хүч хэрэглэн зогсоох тууштай байр суурийг баримтлав. Энэ үед америкийн худалдааны хөлөг онгоцуудын эсрэг умард африкийн Марокко, Алжир, Тунис, Ливийн дээрэмчид зэрлэг балмад үйлдэл хийж байлаа. Тухайлбал 1801 онд америкийн худалдааны хөлөг онгоцуудыг булаан авсан Ливийн дээрэмчдийг өмгөөлөн Триполийн эрх баригчид тэдгээр онгоцуудыг эгүүлэн өгөхийн болзол болгон их хэмжээний мөнгө төлөхийг АНУ-аас шаардаж байжээ. Үүний хариуд Томас Жефферсон хүч хэрэглэх шийдвэр өгсөн нь уг хөлөг онгоцуудыг АНУ-д эргүүлэн өгөхөд хүргэжээ.

1805 онд Триполийн эрх баригчид АНУ-тай гэрээ байгуулж, америкийн хөлөг онгоцуудыг оролдожгүй гэсэн

үүрэг авчээ. Хожим нь умард африкийн бусад орон ч бас тиймэрхүү гэрээ байгууллаа.

Ерөнхийлөгч Томас Жефферсон АНУ-ын нутаг дэвсгэрийг ихэсгэхэд чиглэсэн бодлого явуулж, практик алхам хийж байв. Шинэ зууны эх гэхэд Аппалачийн нуруу, Миссиссипи мөрний хоорондох газарт АНУ-ын нийт хүн амын тавны нэг хувь оршин амьдарч байлаа. Эдгээр оршин суугчид ан хийж, хөдөө аж ахуй эрхэлдэг байсан учир ангийн үс, арьс, бусад зүйл, хөдөө аж ахуйн түүхий эд бүтээгдэхүүнээ Огайо гол, Миссиссипи мөрний усан замаар зөөн, 1795 онд Испанитай байгуулсан Пинкнейн гэрээний дагуу Нью-Орлеаны боомтод авчирч, цааш нь тэнгисийн хөлөг онгоцоор худалдан авагчдад хүргэдэг байв. Гэтэл энэ үед Испани нь өөртөө харьяалагдаж байсан Миссиссипи мөрнөөс Рокки уул нуруу хүртэлх өргөн уудам нутаг- Луизаныг Францад шилжүүлсэн нууц гэрээ байгуулсан байлаа. Наполеоны франц цэргийн хүчирхэг гүрэн болсон байсан бөгөөд бүх Европыг эзлэн эзэнт улс байгуулах эрмэлзэлтэй байжээ. Ерөнхийлөгч Томас Жефферсон энэ аюулыг даруй ухамсарлан ойлгоод, Франц руу элч төлөөлөгч илгээж, Луизаныг худалдаж авах, үүнийг бүтэхгүй бол ядаж Нью-Орлеаны боомтоор АНУ-ын ачаа тээшийг зөөвөрлөж байхыг зөвшөөрүүлэх, хэрэв энэ бүтэхгүй бол Их Британитай нууц хэлэлцээ хийх заавар өгсөн байна. Жефферсон Америкаас Жеймс Монро-г Парис руу явуулж, тэнд суугаа Элчин сайд Роберт Ливингстоны хамт Францтай хэлэлцээ хийх үүрэг өгчээ. Томас Жефферсон өөрийн элч төлөөлөгчдөд бичиж өгсөн заавартаа “би Британиас хамааралтай байх, Францтай дайтахын аль алиныг ч хүсэхгүй байна” гэж бичиж байжээ. Тэгвэл Францын байдал ямар байв аа? Гэвэл Наполеон Европын эх газарт дайн хийж, Британитай дайтахын ирмэг дээр тулж очоод байв. Ийм үед Наполеонд мөнгө хэрэгтэй байсныг америкийн тал сайн мэджээ. Нөгөөтэйгүүр Наполеоныг Америк тивд дайтахад хэцүү болно гэдгийг түүнд ойлгуулсан нэг айхавтар хэрэг явдал тэр үед гарав. Карибын тэнгис дэх Францын эзэмшил Гаити арлын хар арьстан боолчууд өөрсдийн ахлагч Тусан Лүвэртүрээр удирдуулан францын колоничлолын эсрэг

зэвсэгт бослого гаргахад Франц 35000 цэрэг илгээж босогчдыг цус урсган даржээ. Энэ мөргөлдөөнд францын олон цэрэг алагдаж, үлдсэн бараг бүх цэрэг нь халуун орны чичрэг (жёлтая лихорадка) халдварт өвчнөөр нас баржээ. Үүнээс үүдэн францчууд өөрсдийн орноос их далайгаар алслагдсан том орон- АНУ-тай дайтна гэдэг тэдэнд үнэхээр хэцүү болох нь тодорхой болсон буй заа.

Ерөнхийлөгч Томас Жефферсоны илгээсэн төлөөлөгч, Элчин сайд нар Францын талд өөрсдийн ирсэн зорилгоо урьдчилан танилцуулсан нь тодорхой. Уг асуудал нь Наполеонд хүрэхэд тэр “Америктай бид асуудалтай байхыг хүсэхгүй байна. Луизаныг худалдах нь зүйтэй” гэж хэлжээ. Тэгээд 1803 оны 4 дүгээр сард Наполеон гадаад яамны сайд Таллейрон-ыгоо Ливингстон, Монро нартай очиж уулз гэжээ. Уг уулзалтын үеэр Таллейрон: “Та нар бүх Луизаныг худалдаж авахад юу өгөх юм бэ?” гэж асуухад нь мөнгө-доллар өгнө гэж хариулжээ. Тэд хоорондоо хэлэлцээ хийж ярилцаж тохирсоны үндсэн дээр бүх Луизаныг 15 сая америк доллараар худалдан авах болжээ. Жефферсон Үндсэн хуулиар Засгийн газарт газар нутаг худалдан авах эрх мэдэл олгосон заалт байхгүйд сэтгэл түгшиж, энэ тухай Үндсэн хуульд нэмэлт заалт оруулахыг бодож байв. Парисаас Элчин сайд Ливингстон асуудлыг ямар нэг хэмжээгээр удаашруулбал Наполеон шийдвэрээ өөрчилж магадгүйг анхааруулж тэвдүүлж байлаа. Ийм нөхцөлд ерөнхийлөгч, Их хурал уг асуудлыг нийтэд ил гарган тавьж, Луизаныг АНУ-ын хэсэг болгох тухай Францтай гэрээ байгуулах журмаар (гэрээ байгуулах нь ерөнхийлөгчийн үүрэгт ажил бөгөөд түүнийг сайшаах эсэх нь Их хурлын дээд танхим- Сенатын эрх үүрэг учир) гүйцэтгэх нь зүйтэй гэж үзэв. Ингээд Луизанын нутгийг АНУ-ын хэсэг болгох тухай АНУ, Францын хооронд гэрээг 1803 оны 12 дугаар сарын 20 -нд байгуулж гарын үсэг зурснаар уг ажил бүрэн биеллээ олов.

АНУ Луизаныг өөрийн хэсэг болгосноор газар нутгаа 2 дахин ихэсгэв. Өөрөөр хэлбэл түүний газар нутаг 2,1 сая-хавтгай дөрвөлжин километрээр өргөжив. Ерөнхийлөгч Жефферсон хөдөө аж ахуйнхныг аль болохоор баруун тийш зах хязгаарын нутаг руу нүүж очин суурьших, индианчуудыг

бүр баруун тийш нүүх шаардлагатай гэж үзэж байлаа. Тэгээд ч тэр шинээр нэгтгэсэн Луизанын газар нутаг, мөн түүнээс баруун тийш Номхон далайн эрэг хүртэл чухам ямаршуу газар нутаг байгааг сайтар мэдэх зорилгоор хэд хэдэн судалгаа шинжилгээний экспедици явуулжээ. Үүнд: 1804-1806 онд Левиц, Кларк нарын экспедицийг Сент Луизана, Орегоны нутгийг дайруулан баруун хойш Номхон далайн эрэг хүртэл; 1805-1806 онд Пайкийн экспедицийг Сент Луигаас Миссури голыг өгсүүлэн умар зүг- одоогийн Монтана муж улс руу; 1806-1808 онд дахин Пайкийн экспедицийг Сент Луигаас баруун тийш одоогийн Колорадо муж улсын Рокки уулын Пайкийн оргил хүртэл тус тус явуулав. Эдгээр экспедици явуулсаны үр дүнд маш чухал мэдээлэл авсан байна. Эдгээр экспедицийнхэнд нутгийн уугуул хүмүүс - индианчуудтай нөхөрсөг харилцаж байхыг ерөнхийлөгч Жефферсон өөрөө биечлэн зөвлөж байжээ.

Дээрх бүх ажиллагаа нь Томас Жефферсоныг олон түмний дунд их нэр хүндтэй болгож байлаа. Түүнээс Холбооны намынхны болгоомжилж байсан сэрдлэг ч багасав.

1804 оны сонгуулиар Томас Жефферсон улиран сонгогдож хоёр дахь удаагаа Ерөнхийлөгчийн албыг хаших үед АНУ-ын дотоод, гадаад байдалд зарим түгшүүртэй үйл явдал тохиолдлоо. Ялангя Франц, Британий хооронд дайн эхэлсэнтэй холбогдуулан АНУ төвийг сахих байр суурь баримталсанд энэ хоёр орны аль аль нь дургүйцэж америкийн худалдааны хөлөг онгоцуудыг замаас нь булаан авч байсан явдал АНУ-ын Европтой хийдэг худалдаа, наймаанд их хохирол учруулж байлаа. Ийм нөхцөлд Жефферсон 1807 оны гадаадтай хийдэг худалдааг зогсоох тухай Засгийн газрын хориг тавих хуулийг Их хуралд оруулж батлуулав. Ингэснээр уг нь Жефферсон Европын орнууд, түүний дотор Англи, Францад дарамт үзүүлж америкийн худалдааны хөлөг онгоцуудыг тэнгис далайд зорчих эрхийг хүндэтгүүлэх гэж эрмэлзжээ. Дээрх хориг тавих хуулиар америкийн боомтуудад ч гадаадын хөлөг онгоцууд хүлээж авахыг болон гадаадад америкийн хөлөг онгоцууд зорчихыг хориглосон байлаа. Гэтэл Жефферсоны санаачилж гаргасан энэ шийдвэр үр дүн

өгсөнгүй. Учир нь үүнээс болж америкийн зах зээл гаднаас авдаг байсан элсэн чихэр, болон бусад зүйлээр туйлын их ховордож, хөлөг онгоцууд ажилгүй зогсон, дотоодын дамын панзчид өөрсдийн хувийн шугамаар олж ирсэн дээрх нэр төрлийн бараа таваар, бүтээгдэхүүнийг маш өндөр үнээр зарж ихээхэн ашиг олж байв.

Иймд дээрх хориг тавих шийдвэрийг америкийн засгийн газар 1809 онд хүчингүй болгоход хүргэсэн байна. Түүний оронд өөр хууль гаргаж, түүгээр Британи, Франц хоёроос бусад оронтой худалдаачдыг чөлөөтэй худалдаа хийж болох тухай зааж, харин Англи, Франц хоёрыг хэдийд америкийн худалдааны хөлөг онгоцуудыг хүндэтгэдэг болсон цагт арилжаа наймаа хийж болохыг анхааруулжээ.

Америкийн худалдааны хөлөг онгоцуудыг тэнгис далайд зорчуулахгүй байсан буруутан нь Англи, Франц хоёр мөн бөгөөд америкийн олон нийт бүр ч их дургүйцэж байлаа.

АНУ-ын зах хязгаарын районы цагаан арьстан суурьшигчид Британийг индианчуудад зэр зэвсэг нийлүүлэн тэдний эсрэг турхирч байна гэж үздэг байв. Цагаан арьстан анхны суурьшигчид баруун тийш нүүж, нутгийн уугуул оршин суугчид - индианчуудыг Миссиссиппи мөрнөөс зүүнтээх төрөлх газар нутгаас нь элдэв арга мэх хэрэглэн шахан зайлуулж байжээ. Тухайлбал Индиана нутгийн захирагч Уильям Генри Гаррисон 1795-1805 онд индианчуудыг 19,4 сая га талбай эзхий газар нутгаас нь шахан зайлуулсан байна.

Ийм ч учраас 1808 оны орчим Шауни овгийн индианчууд өөрсдийн газар нутаг, омгийг аврахын тулд эрэлхэг дайчин Тикумшехээр удирдуулан захирагч Гаррисоны эсрэг тэмцэлд босч, тэдэнтэй крик омгийнхон нэгдэн нийлэв. Гаррисон тэмцэлд боссон индианчуудыг цус урсган дарж, тэдний тосгоныг галдан шатаажээ. Үүнийг босогчдын штаб байрлаж байсан Типпекано газрын нэрээр Типпекано-гийн тулалдаан гэдэг байна. Энэ тулалдаан 1811 оны 11 дүгээр сарын 7-нд болжээ. Ингэснээр ямар ч л байсан нэлээд хугацаанд энэ нутгийн индианчууд хоорондоо авсан нийлж

чадахгүй болж тархай бугархай хэсэг хэсгээрээ л тэмцлээ үргэлжлүүлж байлаа.

Ер нь баруун умардын нутаг болон өмнөдийн нутагт индианчууд цагаан арьстан суурьшигчидтай мөргөлдөж байгаа нь британичуудын өдөөн хатгалга, үйлдэл гэж нэрлээд америкчууд үзэж байв. Хэрвээ Британитай дайн эхэлбэл түүнд харьяалагддаг Канад, түүнчлэн түүний хамсаатан Испанид харьяалагддаг Флоридыг эзэлж болно гэж тэд үздэг байлаа. Ийм ч учраас Их хурал дахь хэдэн залуу бүгд найрамдахчууд, тухайлан Кентукийн захирагч Генри Клэй, Өмнөд Каролины захирагч Жон Калхаун нар Британиас америкийн баруун умардад индианчуудыг турхирдагийг болиулахын тулд Британитай дайтах хэрэгтэй гэж их ярьдаг байв. Тэднийг хүмүүс “дайны харцагууд” гэж нэрлэдэг байжээ. Иймэрхүү “дайны харцагууд”-ын шаардлагаар Их хурал 1812 оны бдугаар сарын 19-нд Британид дайн зарлалаа. Энэ үед шинэ ерөнхийлөгчөөр сонгогдсон Жеймс Мэдисон үүнийг зөвшөөрсөн нь мэдээж.

Гэтэл АНУ нь Британитай дайтах бэлтгэлгүй байжээ. Түүний арми нь 7000 цэрэгтэй байснаас гадна ихэнх офицер нь дайны туршлагагүй байв. Америкийн цэргийг цагдаа нартай нийлүүлсэн ч Британи цэргийн тоогоор ихээхэн давамгайлж байлаа. Америкийн тэнгисийн флотыг Английнхтай зүйрлэх ч аргагүй байв. АНУ тэнгисийн цэргийн 16 хөлөг онгоцтой байсан бөгөөд нэмж хөлөг онгоц байгуулъя гэхэд Их хурал мөнгө хөрөнгө баталж өгөөгүй байна. Дайны асуудлаар америкийн нийгмийн санаа бодол ч хуваагдмал байв. “Дайны харцагууд” мэтийн хүмүүс Британитай дайтах нь зүйтэй гэж үзэж байхад АНУ-ын зүүн хойд нутгийн худалдаачид энэ дайныг “Ноён Мэдисоны дайн” гэж нэрлэн гаашаахгүй байлаа.

Дайн эхэлмэгц Британи өөрийн тэнгисийн цэргийн хүчний ихээхэн давуу байдлаа ашиглан Атлантын далайн АНУ-ын эргийг тэнгисийн цэргийн хөлөг онгоцуудаараа бүслэн авч, америкийн боомтуудыг гадаад ертөнцөөс таслав. Ингэхэд нь америкчууд Британийн колони Канад руу дайрч түүний нийслэл Йорк (одоогийн Торонто) хотыг дайран

эзэлж галдан шатаасан байна. 1814 онд британичууд АНУ-ын зүүн хойд район болон Атлантын эргийг довтолж хэд хэдэн хотыг эзэлж галдан шатаалаа. Мөн оны 8 дугаар сард Британийн тэнгисийн цэргийн хөлөг онгоцууд Чесапьюкийн тохойд ирж, нийслэл Вашингтон хотыг эзлэхээр цэрэг илгээн, төдий л удалгүй эзлэн авав. Йорк (хот)-ыг америкчууд шатаасны хариу болгож, британичууд Их хурлын "Капитол" ордон, цагаан байшинг шатаажээ. Харин Ерөнхийлөгч Жеймс Мэдисон гэргийнхээ хамт хотыг британичууд эзлэхээс өмнө зугтааж амжсан байлаа. Түүнчлэн тэд өөрсдөдөө засгийн газрын зарим чухал баримт бичиг, Жорж Вашингтоны эхнэртэйгээ хамт авахуулсан зургийг авч гарчээ.

Вашингтон хотыг эзлэн авсаны дараагаар британийн цэргүүд умар зүг- Балтимор хот руу хөдөлжээ. Макгенри цайзын ойролцоо тэд америкийн хүчинтэй тулгарч, ширүүн тулалдаан болов. 1814 оны 9 дүгээр сарын 14-нд тулалдаан дуусчээ. Уг тулалдааныг Чесапьюкийн булан дахь британийн хөлөг онгоцноос ажиглаж байсан америкийн хоригдол Фрэнсис Скотт Кей тулалдааны дараа тэр газарт АНУ-ын төрийн далбаа намирсангай холбогдуулан "Улаан туяа цэцэрүүлсэн одод" эсэн шүлэг зохиосныг нь хожим хөгжмийн ая оруулсанаар Америкийн төрийн сүлд дуулал болгосон байна.

Хэдийгээр Британи тэнгисийн цэргийн хөлөг онгоцууд болон цэргийн тоогоор хавьгүй давуу байсан ч гэсэн америкчууд тэнгис далайд ч, хуурай газрын тулалдаанд ч туйлын эрэлхэг зориг, авхаалж самбаатай байлдаж байлаа. Таван нуур, тэдгээрийн зарим боомтод болон Атлантын далайн эргийн боомтууд, мөн далайд британийн цэргийн хөлөг онгоцуудтай эрэлхэг тулалдаж амжилт гаргаж байв. Америкчуудын энэ амжилтад олон зууны турш эсрэг талынхаа байлдааны хөлөг онгоцуудыг ямагт сөнөөн дарж байсан британичууд хүртэл гайхацгааж байжээ. Тэгээд ч тэд америкийн эрэг орчмоос байлдааны хөлөг онгоцуудаа татан авч байлаа.

1814 он гэхэд АНУ, Их Британийн хоорондын дайнд аль аль нь бүрэн дүүрэн ялалт байгуулах найдвар бага болжээ.

Ингээд Бельгийн Гент хотноо дайтагч хоёр тал энх тайван байдал тогтоох хэлэлцээ хийж эхлэв. Хоёр тал дайтахыг зогсоож, дайны өмнө байсан байдлаар хил хязгаарын маргаантай асуудлыг шийдэх, АНУ, Канадын хилийн дагуух маргаантай асуудлыг зохицуулах комисс байгуулсан байна. Энэ Гентийн гэрээнд 1814 оны 12 дугаар сарын 24-нд хоёр тал гарын үсэг зуржээ.

Гэвч энэ үед зарим газарт байлдааны ажиллагаа явагдсаар байлаа. Тухайлбал 1815 оны 1 дүгээр сарын 8-нд Нью-Орлеаны дэргэд америкийн генерал Андро Жексоны командалсан цэрэг британий цэрэгтэй тулгарч цаг хагасын турш байлдав. Нью-Орлеаны энэ тулалдаанд британий алуулсан ба шархадсан цэргийн тоо 2000 болсон байхад генерал Андро Жексоны цэргээс 8 хүн алагдаж, 13 хүн шархадсан байна. Нью-Орлеаны тулалдаан дуусч байх үед АНУ, Британий хооронд энх тайван байдал тогтоох тухай байгуулсан Гентийн гэрээ яг хүчин төгөлдөр болж байв. Нью-Орлеаны тулалдаан дайны явцыг нэг тийш болгосон ач холбогдолгүй байлдааны ажиллагаа байсан боловч генерал Андро Жексоны нэр хүндийг дээшлүүлэн дайны баатар болсон нь хожим түүнийг АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдоход их тус болжээ.

Ийнхүү 1812-1814 оны Америк, Британий хоорондын дайн АНУ-д ашигтай дууссан байна. Зарим хүмүүс энэ дайнаар дорвитой юу ч хожоогүй гэж байхад америкийн олонхи түүхчид, улс төрийн зүтгэлтнүүд арай өөрөөр үздэг ажээ. Тэд үзэхдээ дайн чухал үр дүнд хүргэсэн, 1815 он нь АНУ-ын түүхэнд эргэлтийн үе болсон гэдэг байна. Яагаад вэ? Гэвэл урьд нь гадаадын улс гүрнүүд АНУ-ын эрхийг төдий л бүрэн хүндэтгэхгүй, түүний худалдаа арилжаанд байнга саад хийж байсан бол энэ дайны дараахь үеэс тэд АНУ-тай арай хүндэтгэлтэй харьдах болжээ. Улс орны дотоодод ч гэсэн америкчууд улс орныхоо хүчинд итгэл үнэмшил, бахархалтай болж, ялалт байгуулсан зэвсэгт хүчин, удирдлагадаа баяр талархал илэрхийлэн, тэдний үйл ажиллагааг сайшаан дэмжих явдал мэдэгдэхүйц нэмэгдсэн нь илт харагдаж байжээ. Тэгээд ямар ч байсан АНУ-ын зүүн хойд, өмнөд, өрнөд нутгийнхан

хоорондынхоо зарчмын гэж үзэж болох санал зөрөлдөөн, маргаанаа нэг хэсэгтээ л лавтайяа намдаажээ.

Эдийн засгийн хувьд 1812-1814 оны дайн АНУ-ын байдлыг хүчтэй болгон бэхжүүлсэн байна. 1800-гаад оны бүр эхэнд АНУ бөс даавуун болон хүнсний олон нэр төрлийн барааг гадаадаас худалдаж авдаг байсан бол 1812-1814 оны дайн, түүний өмнө Томас Жефферсоны Засгийн газрын гаргасан хориг тавих зэрэг шийдвэр нь АНУ-д бөс даавууны үйлдвэртэй болох, хүнсний хэрэглээний олон нэр төрлийн барааг америкчууд өөрсдөө үйлдвэрлэж чаддаг болоход тус дөхөм үзүүлжээ. Өөрөөр хэлбэл ямар ч л байсан бөс даавуун эдлэлийг АНУ гадаадаас авдагаа больсон байна. Хөлөг онгоцны үйлдвэрлэл, худалдаа, арилжаа наймаанд ч өсөлт бий болов. Улс орны өр шир ч ихээхэн багасч, өчүүхэн хэмжээний өртэй үлджээ.

Товчоор хэлэхэд, 1815 оноос шинэ тулгар орон- АНУ дотооддоо ард түмнийхээ дэмжлэг, олон улсын талбарт гадаадын улс гүрний хүндэтгэл олох нь өсөн нэмэгдэж, энх тайван хөгжил цэцэглэлтийн замаар замнах боломжтой болсон байна.

(Үргэлжлэл нь дараагийн дугаарт
нийтлэгдэнэ)